

**ӨМЧИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН ПҮРЭВЖАВЫН ТҮВШИНЖАРГАЛЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт /	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
Зорилго 2. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажиллана. (Хуулиар тусгайлан олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилго)							
Зорилт 2. Нийслэлийн өмчийн харилцааны менежментийн оновчтой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх замаар өмчийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах, эдийн засгийн чадавхыг дээшлүүлнэ.							
1.	Арга хэмжээ № 2.12.Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад дотоодын зээл, төсөл хөтөлбөр, хандив бэлэглэлээр шинээр бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулах	Бүртгэсэн хөрөнгийн дүн, сая төгрөг	-	НИТХ-ын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, ҮХХХК-ын шийдвэрээр бий болсон хөрөнгийг хуулийн этгээдийн тайлан баланст бүртгэсэн байна.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын төсөлд 2025 оны 1/2078, 2/2043 тоот албан бичгээр тогтоолын төсөл өргөн барьсан. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1261, А/1528 дугаар захирамжаар 6 тээврийн хэрэгсэл нийслэлийн өмчид бүртгэсэн. Мөн ҮХХХК-ын хурлаар 2025 оны газрын даргын А/293, А/475 дугаар тушаалаар 127,725,000.0 төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж	2025.07.01-2025.11.13	100%

					бүртгэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна.		
2.	Арга хэмжээ № 2.13.Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн баланст бүртгэлтэй хөрөнгийг акталж, данснаас хасах асуудлыг шийдвэрлүүлэх	Хассан хөрөнгийн дүн, сая төг	-	НИТХ-ын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, ҮХХХК-ын шийдвэрээр хөрөнгийг тухайн хуулийн этгээдийн балансаас хассан байна.	ҮХХХК-ын хурлаар 2025 оны газрын даргын А/293, А/385, А/388, А/387, А/386, А/380, А/383, А/381, А/384, А/373, А/379, А/382, А/400, А/477, А/475 дугаар тушаалаар 15 байгууллагын 597,910,022.04 төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, барилга байгууламж, программ хангамж, бусад хөрөнгийг данснаас хасах ажлын зохион байгуулсан байна.	2025.07.01-2025.11.13	100%
3.	Арга хэмжээ № 2.14.Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн баланст бүртгэлтэй хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх	Шилжүүлсэн хөрөнгийн дүн, сая төг	-	Хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу НИТХ-ын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, ҮХХХК-ын шийдвэрээр хөрөнгийг тухайн хуулийн этгээдийн балансаас хассан байна.	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1261, А/1522 дугаар захирамжаар 3 байгууллагын 3,412,154,973.04 төгрөгийн 28 тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжүүлсэн. Мөн ҮХХХК-ын хурлаар 2025 оны газрын даргын А/294, А/292, А/389 дугаар тушаалаар 3 байгууллагын	2025.07.01-2025.11.13	100%

					181,506,476.00 төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж балансаас балансад шилжүүлсэн байна.		
4.	Арга хэмжээ № 2.15.Хувийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийслэлд үнэ төлбөргүй шилжүүлэн өгч байгаа нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэх ажлыг зохион байгуулах	Хөрөнгийн дүн, сая төг	-	Ашиглалтыг хариуцах байгууллагын баланст бүртгэх асуудлыг өргөн барьж шийдвэрлүүлсэн байна.	Тайлант хугацаанд бүртгэх хүсэлт ирээгүй.	2025.07.01- 2025.11.13	-
5.	Арга хэмжээ № 2.17.Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын хурлаар оруулан шийдвэрлүүлэх	Хурлын тоо, Хөрөнгийн үнийн дүн, сая төгрөг	-	Хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг хэлэлцэж шийдвэрийг нийслэлийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлсэн байна.	Тайлант хугацаанд ҮХХХК-ын 6 удаагийн хурлаар давхардсан тоогоор 39 байгууллагын 1,507,765,362.74 төгрөгийн хөрөнгийг хэлэлцүүлэн газрын даргын 33 удаагийн тушаал, 9 удаагийн дахин үнэлсэн албан бичгийг боловсруулан батлуулсан байна.	2025.07.01- 2025.11.13	100%
Зорилго 3. Хуулиар олгогдсон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх							
Зорилт 3. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, эрх зүйн баримтуудыг шинэчлэн боловсруулна.							
6	Арга хэмжээ 3.4 Байгууллагын үйл ажиллагаанд	Үйл ажиллагаан ы	-	Чанарын удирдлагын тогтолцоог	Тайлант хугацаанд MNS ISO 9001:2016 чанарын удирдлагын	2025.07.01- 2025.11.13	-

	MNS ISO 9001:2016 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажилд оролцох	хэрэгжилтийн хувь		нэвтрүүлэхтэй холбоотой байгууллага дээрх үйл ажиллагаанд оролцсон байна.	тогтолцоогтой холбоотой ажил ирээгүй болно.		
7	Арга хэмжээ 3.5 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намар мод тарих	Модны тоо, Өртөг, сая төг	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2025 оны хаврын "Бүх нийтийн мод тарих", тариалсан мод, бут, сөөгийг арчлан хамгаалах арга хэмжээний хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 03- ны өдөр байгууллагын хамт олноороо Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэнд 160 хайлаас суулгаж, усалж, арчилснаас гадна өнгөрсөн онуудад суулгаж, ургуулсан мод, бут, сөөгөө усалгааг хийсэн.	Мод тарих арга хэмжээнд биечлэн оролцох эсвэл тарих мод худалдан авахад оролцсон байна.	Мод тарих арга хэмжээнд биеэр оролцох боломжгүй байсан учир мөнгө хураалгасан.	2025.07.01- 2025.11.13	90%
8	Арга хэмжээ 3.7 Албан хаагчдын албан үүргээ, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилтын	Сургалт, семинарын тоо	Дараах сургалтад мэдлэг ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр хамрагдсан байна. Үүнд: 1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан	Сургалтад хамрагдсан байна.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Зохион байгуулсан "Нийслэлийн таван жилийн үндсэн чиглэл боловсруулах	2025.07.01- 2025.11.13	100%

	хүрээнд зохион байгуулсан сургалт, семинар, олон нийтийн ажилд оролцох		<p>Стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хамрагдсан.</p> <p>2.Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэнүүдтэй уулзалт, сургалт зохион байгуулахад нэгжийн хамт олны хамт оролцсон.</p> <p>3. Нийслэлийн онцгой байдлын газраас зохион байгуулсан гамшгийн үеийн сургалт мэдээлэлд танхимаар болон биечлэн оролцсон.</p> <p>4.Нийслэлийн өмчийн нэгдсэн программын сургалтад 3 удаа хамрагдсан байна.</p>		боловсруулах” сургалт, Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн системийн сургалтад 2025.10.27-10.29-ний өдрүүдэд хамрагдсан.		
Зорилт 6. Албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах, баримт бичгийн эмх цэгц, бүрдэл, хадгалалт, ашиглалтыг сайжруулна.							
9	Арга хэмжээ 6.1 Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон стандартыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд	Албан бичиг, өргөдөл гомдлын тоо, хэрэгжилтийн хувь	Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон стандартыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж нийт 3 албан бичиг ирснийг цаг тухай бүр шийдвэрлэж, 5 албан бичгийг иргэн, аж ахуй нэгжид илгээсэн байна.	Албан бичиг, өргөдлийг хугацаа хэтрүүлэлгүй, зөрчилгүй шийдвэрлэсэн байна	Тайлант хугацаанд нийт 59 албан бичиг ирснийг хугацаанд нь шийдвэрлэн хариу өгсөн байна. Мөн 35 албан бичиг боловсруулан холбогдох байгууллагад EDOC системээр шилжүүлсэн байна. Өргөдөл 1 ирснийг	2025.07.01-2025.11.13	100%

	мөрдөн ажиллаж албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх		Мөн өргөдөл гомдлын системээр 1 гомдол ирснийг зохих журмын дагуу зөрчилгүй шийдвэрлэсэн байна. Иргэний гомдлын шинжтэй өргөлдийг 2025 оны 3/327 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн байна.		зохих журмын дагуу шийдвэрлэв. Албан бичиг, өргөдөл гомдлын зөрчилгүй, хугацаа хэтрүүлэн шийдвэрлээгүй ажилласан байна.		
10	Арга хэмжээ 6.2 Архивын тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, байгууллагын архивын сан хөмрөгийг бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	Ажлын үр дүнд болон явцад үүссэн албан бичиг бусад баримтыг архивын санд хадгаламжийн нэгж болгон хүлээлгэн өгсөн байна.	Ажиллах хугацаанд үүссэн зохион байгуулалт болон захирамжлалын 2 архивын баримтыг зохих журмын дагуу баримт хүлээлцэх 01 дүгээр актаар Захиргаа удирдлагын хэлтэст 2025.11.13-ны өдөр хүлээлгэн өгөв.	2025.07.01-2025.11.13	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Арга хэмжээ 1. Үйл ажиллагаатай холбоотой шинэчлэгдсэн хууль, дүрэм, журам болон	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Тухайн жил нийслэлээс баталсан бодлогын баримт бичгүүд стратеги төлөвлөгөөтэй танилцан	Үйл ажиллагаатай холбоотой мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн систем нэвтрэхтэй системийн бүртгэл нээх цахим сургалтын дагуу 2025 оны 08 дугаар сард нийслэлийн 800 гаруй байгууллагын бүртгэл мэдээллийн	2025.07.01-2025.11.13	100%

	бусад холбогдолтой эрх зүйн актуудыг судалж мэдлэг чадвараа дээшлүүлэх		холбогдох сургалтад хамрагдсан. Мөн Сангийн яамнаас гаргасан Улсын салбарын дотоод аудит, Монголын үндэсний дотоод аудитын холбооны Олон улсын мэргэжлийн практик хүрээ, нэр томъёоны тайлбар толь зэргийг чиг үүргийн хүрээнд судалсан.		шинэчлэгдсэн программд оруулж, мэдлэгээ нэмэгдүүлсэн.		
2	Байгууллага болон бусад газраас зохион байгуулсан сургалт, семинар болон бусад олон нийтийн ажилд оролцох	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Дараах сургалт, олон нийтийн арга хэмжээнд хамрагдсан байна. Үүнд: 1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан Стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хамрагдсан. 2.Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Хяналт шалгалтын	Олон нийтийн арга хэмжээнд хамрагдсан байна.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Зохион байгуулсан “Нийслэлийн таван жилийн үндсэн чиглэл боловсруулах боловсруулах” сургалт, Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн системийн сургалтад 2025.10.27-10.29-ний өдрүүдэд хамрагдсан. Мөн байгууллагын дотоодод зохион байгуулсан арга хэмжээнд идэвхтэй оролцсон.	2025.07.01-2025.11.13	100%

			<p>хэлтсийн мэргэжилтэнүүдтэй уулзалт, сургалт зохион байгуулахад нэгжийн хамт олны хамт оролцсон.</p> <p>3. Нийслэлийн онцгой байдлын газраас зохион байгуулсан гамшгийн үеийн сургалт мэдээлэлд танхимаар болон биечлэн оролцсон.</p> <p>4. Нийслэлийн өмчийн нэгдсэн программын сургалтад 3 удаа хамрагдсан байна.</p> <p>5. Бүх нийтийн цэвэрлэгээ болон мод тарих араг хэмжээнд тус тус идэвхтэй оролцсон байна.</p> <p>6. Байгууллагын спорт хамтлагт орж, хамт олноороо спортын арга хэмжээнд идэвхтэй оролцдог.</p>				
--	--	--	---	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

1.1.1.	Цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор өгч буй үүрэг даалгавар	-Ажлын хэсгийн дарга, хурал -Нэгжийн дарга, хурал -Байгууллагын удирдлага, хурал	<p>Нэмэлт ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Газрын даргын 2025 оны А/18 дугаар тушаалаар байгууллагын 4 жилийн стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн нарийн бичгээр томилогдон дараах ажлуудыг хийсэн. Үүнд тушаалын дагуу хийх ажлын төлөвлөгөөг ажлын хэсгийн даргаар 2025.09.02-ны өдөр батлуулсан. Гишүүдийн боловсруулсан төлөвлөгөөний төслийг нэгтгэн 2025.09.19-ны өдөр санал авах хуудсаар байгууллагын стратеги төлөвлөгөөний төслийн эцсийн байдалд санал авч дуусч, Ажлын хэсгийн даргад танилцуулж, Захиргаа удирдлагын хэлтэст хүлээлгэн өгсөн. ✓ Хэлтсийн мэргэжилтэн С.Сэржжаргал 1 сарын чөлөөтэй байсан хугацаанд хариуцаж байсан үйлдвэрийн газруудын хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой шийдвэрүүд болон менежментийн асуудлаар захирамж, тушаал албан бичиг танилцуулга боловсруулсан. ✓ Байгууллагын архивын үзлэгт бэлдэх ажлын хүрээнд 2020-2024 оны өргөдөл гомдлын архивын нөхөн бүрдүүлэлтийг хийж, 4 боть баримт болон 2024 оны нийт өргөдлийг цахим архивыг хийсэн. 	Биелэлтийн хувь: 90%
	Эхлэх / дуусах огноо:		Эхэлсэн, дууссан огноо:2025.08.23-2025.09.30	

ТАЙЛАН ГАРГАСАН:

ӨУЗХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

(Албан тушаал)



 (П.Түвшинжаргал)
 (Нэр, гарын үсэг)

2025. 11 . 13

(Огноо)

----oOo---